

**12 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ****Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Төрийн үйлчилгээний чиглэлээр:** Сумын 2022 оны үйл ажиллагааны 11 тайланг үнэлгээ цахим системд цаг хугацаанд нь тайлагнасан. Хууль эрх зүйн ажлын мэдээ, бичмэл тайланг гаргаж хууль эрх зүйн хэлтэст хүргүүлж ажилласан. Сумын ИТХ-ын ээлжит 11-р хуралдаанаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг тайлагнаж сумын ИТХ-ын төлөөлөгчид сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 6 бүлгийн 193 арга хэмжээний хэрэгжилтийг Хангалттай гэсэн үнэлгээг өглөө. Мөн сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөө, сумын төсвийг хэлэлцүүлж батлуулсан.

Татварын төлөвлөгөө 12 сарын байдлаар 660639.6, гүйцэтгэл 690824,3 биелэлт 104,5% - тай байна.

**Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд**

Нийгмийн даатгалд жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд ЭМД-д 620 иргэн. СДД-д 235 иргэн хамрагдаж тэтгэвэр 601 иргэн авч байна.

**ЕБС СҮХБААТАР АЙМГИЙН 2022 ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД**“-шалгаруулах арга хэмжээг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 30 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж Хүмүүнлэг, энэрэнгүй сайн үйлс төрөлд 11-р ангийн 1 сурагч шалгарлаа. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан "Судар эгшиглэн- 2022" төслийн уралдаанд Насанд хүрэгчдийн төрөлд 3-р байр МХУЗ-ын 1багш Сурагчдын бага ангийн төрөлд 5-р ангийн 1 сурагчТусгай байр, Дунд ангийн төрөлд 3-р байр 8-рангийн 1 сурагч, Ахлах ангийн төрөлд 12-р ангийн 1сурагчТэргүүн байр Цом, 11-р ангийн 1 сурагч 3-р байр, " Шилдэг уншигч" анги хамт олноор 8а анги, Шилдэг бүтээлийн уралдаанд Дэд байранд ахмад 1 багш тус тус байр эзэлж амжилттай оролцсон

Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний урчадвар, энтрепренершипийн боловсрол олгохнь" төслийн энэ хичээлийн жилийн намрын элсэлтийн ЕБС-ийн 48, НТБ-ын 37 залуучуудтанхимын болон хосолсон сургалтаар суралцаж төгслөө.

Мөн төслийн дараагийн шат болох бичил төсөл бичих уралдаанд нийт 8 төсөл бичиж 1-р шатны шалгаруулалтанд бүгд тэнцэж 2-р шатны РИТСН-4 өдөрлөгөөр 6 төсөл дэмжигдлээ. 2022 оны Амжилтын баярыг сургууль хамт олноороо дүгнэж зохион байгуулсан .

Энэ оны Амжилтын баяраар:

Оны шилдэг сурагчид

- Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ийн хүрээнд Сумын Засаг Дарга ивээн тэтгэж "Сайхан бичигтэн анги" МАСС-ын олимпиад /500.0 мян төг/
- Математикийн сургалтын чанарыг сайжруулах хүрээнд Сумын ИТХ-ын Дарга ивээн тэтгэж математикийн МАСС-ын олимпиад /500.0 мян төг/
- Бүх нийтийн англи хэлний боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Сумынтамгын газрын дарга ивээн тэтгэж англи хэлний МАСС-ын олимпиадуудыг зохион байгуулсан үр дүнг танилцуулж анги хамт олныг шагнаж урамшууллаа. /500.0 мян төг/
- ЭЕШ-нд бэлтгэж байгаа 7 хичээлээр ахиц амжилт гаргаж байгаа багш нараа сургуулийн захиргаанаас 20%шагнаж урамшууллаа. /1470.0 мян төг/

- "Хүүхдийн элч"-ийн нэрэмжит шагнал өргөмжлөл, МНТ- боть номоор нийт 10 ангийг 5ш номоор тус тус шагнав. Хүүхдүүдийг Монголын үндэсний соёлын гайхамшигт дурсгал бичиг болсон эх хаадын угсаа гаралтай түүхтэйгээ танилцуулах зорилгоор МНТ-зохиолыг шагнал болгон гардуулав./500.0төг/

Хамтын ажиллагааны хүрээнд Баруун-Урт сумын 2 дугаар бүрэн дунд сургуультай хамтын ажиллагааны эхний алхам хийгдэж анхны уулзалтаар сургуулийн менежмент, МХБ-ийн үйл ажиллагаа, ЭЕШ-нд бэлтгэхэд анхаарах зүйлүүд зэрэг чиглэлүүдээр харилцан ярилцаж хамтран ажиллалаа.

**Хүүхдийн цэцэрлэг:** 2022 онд хүн бүр өөрийгөө хөгжүүлэх, ажлын бүтээмж үр дүнгээ сайжруулах чиглэлээр, 4-5 зорилго дэвшүүлсэн ба эдгээрийг нэгтгэн дүгнэх ажлыг зохион байгууллаа. Энэ онд, байнга л ажил үйлс бүх талаараа жигд сайн байдаг нэгнийг шилдэг, сайн гэж шалгаруулахаас илүү өөрийгөө хөгжүүлсэн, өмнөхөөсөө ахисан түвшинд ажилласан багш ажилчдыг урамшуулах урамшууллын бодлого баримталж ажиллав. Өмнөө тавьсан зорилгоо бүрэн биелүүлж ажилласан багш ажилчдыг байгууллагын нэгдсэн үйл ажиллагаанд урамшуулна.

1.2. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай" 2022 оны А/368 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам"-ийн дагуу зохион байгуулагдах "Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажил гүйцэтгэлийн үнэлгээ"- улсын хэмжээнд зохион байгуулагдлаа. Багшийг, 1.Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны ахиц, үр дүн , 2.Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн, 3.Цэцэрлэгийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, оруулсан хувь нэмэр гэсэн шалгуурын дагуу багш , эцэг эх, удирдлагууд үнэлсэн. Энэхүү үнэлгээгээр тус цэцэрлэгийн багш нар 1-3-р түвшинд үнэлэгдсэн ба аймгийнхаа хэмжээнд хамгийн өндөр үнэлэгдсэн байна.

1.3. Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2022 оны 01\420 тоот албан тоотын дагуу Боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ улсын хэмжээнд зохион байгуулагдлаа. 1.Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт,2. Суралцагчийн хөгжил хамгаалал, 3.Багш ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа, 4.Сургалтын орчин бүрдүүлэлт, 5.Удирдлагын манлайлал, менежмент, 6.Сургалтын байгууллагын талаар хэрэглэгчийн сэтгэл ханамж гэсэн 6 чиглэлээр багш нар , эцэг эх, БШУГ-ын дарга мэргэжилтнүүд үнэлж, энэхүү үнэлгээгээр тус цэцэрлэг 1- р түвшинд үнэлэгдэж, байгууллагын менежментийг сайжруулах болон ажилчдын урамшуулалд зарцуулагдах 39.657.600 төгрөгийн зардал олгогдсон. Урамшууллыг батлагдсан журмын дагуу зарцуулсан.

1.4. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан "Судар эгшиглэн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг байгууллага дээрээ бүтэн жилийн турш амжилттай зохион байгуулж, үр дүнгээр " Шилдэг уншигч байгууллага" төрөлд ТЭРГҮҮН байр, "Шилдэг бүтээлч байгууллага"-ын төрөлд ТЭРГҮҮН байр, эрхлэгч Д.Ариунмөнх "Насанд хүрэгчдийн шилдэг уншигч" төрөлд ДЭД байр, багш Т.Давааням, туслах багш А.Оюунтуяа нар "Зохион байгуулагчдын нэрэмжит шагнал" тус тус хүртсэн. Мөн "Талын түрлэг" сэтгүүлчдийн бүлгэмээс байгууллагын номын санд Сүхбаатар аймгийн зохиолчдын номын багцыг бэлэглэв. Бүтэн жилийн хугацаанд үндсэн ажлынхаа хажуугаар бүтээлч ажлуудаа амжуулдаг.

1.5. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зардлын 35%-ийг байгууллагын менежмент , хэвийн үйл ажиллагааг хангах зардалд, 65%-ийг багш ажилчдыг урамшуулах зардалд зориулах журмын дагуу зарцуулж, байгууллагын хүндрэлтэй байгаа тог хэлбэлзэх үед шууд асаах мотор, 1-р давхрын хивс, гал тогоонд гурил элдэгч хэрчигч, бүх бүлгүүдийн ариун цэврийн өрөөний гэмтэл засварлах, хүүхдийн хөнжил гудас шинэчлэх, үүдний хаалганы дээр хөшгөн халаалт гэх мэт зүйлсийг шийдвэрлэсэн. Эдгээрийг шийдвэрлэхдээ бүх багш

ажилчдаас нэн шаардлагатай зүйлсийн санал ав, багш нарын зөвлөлөөр хэлэлцэж эрэмбэлээд, жагсаалтын дагуу эхнээс нь хэрэгжүүллээ.

1.6. Энэ хичээлийн жилд шинээр ажилд орсон ажилчидтай хамтарсан уулзалт ярилцлага хийж, ажиллах хугацаанд хэрхэн ажилласан, ямар алдаа дутагдал гаргасан, ажлын цаг ашиглалт ямар түвшинд байгаа, дүрэм журмаа хэрхэн баримталж ажиллаж байгаа талаар хүн тус бүр дээр дүгнэлтээ танилцуулан, мөн тэднээс санал бодлыг нь сонсож, зөвлөгөө чиглэл өгөв. Энэ ажлын үеэр түр тушаалаар ажилд орсон 2 ажилтны гэрээний хугацаа дууссан, хангалттай түвшинд ажиллаагүй учир цаашид гэрээг сунгахгүйгээр цуцлав. Харин бусад буюу шинээр орсон 5 ажилтанд харилцаа, хандлага, ажлын хариуцлага, дэг журмын талаар үүрэг, зөвлөгөө, чиглэл өгч гэрээг сунгаж үргэлжлүүлэн ажиллуулахаар болсон.

1.7. Байгууллага дээр үйл ажиллагаа явуулдаг Залуучуудын зөвлөл, Үйлдвэрчний эвлэл, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, Сургалтын баг, Хувилбарт сургалт, Номын сан гэх мэт ажлын хэсэг, баг, зөвлөлүүдийн тайлан хэлэлцэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ онд М.Миеэсүрэн ахлагчтай Залуучуудын зөвлөл бусад зөвлөл, багуудаа манлайлан маш сайн ажилласан учир, 2023 онд зохион байгуулах 1 том ажлын санхүүжилтийг байгууллагаас бүрэн шийдвэрлэхээр урамшуулав.

1.8. Аймгийн засаг даргын дэмжлэгээр 13 сая төгрөгийн санхүүжилт бүхий ухаалаг самбарыг шийдвэрлэж өглөө. Энэ нь багшийн хөгжилд оруулсан маш том хөрөнгө оруулалт юм. Ухаалаг самбартай болсноор багш бүр цахим хичээл боловсруулах, цахим сургалт зохион явуулах, гэх мэтээр мэдээлэл харилцааны технологийн ур чадвар нь ахиж, сургалтыг олон хэлбэрээр төлөвлөж зохион явуулах ур чадвартай болно.

1.9. Жил бүр байгууллагын ахмад ажилчид болон бүх багш ажилчдад түлээ нүүрсний дэмжлэг үзүүлдэг уламжлалтай. Үүний дагуу энэ сард нийт 4 ахмадад тус бүр 2тн, 36 багш ажилчдад тус бүр 1.3тн нүүрс олголоо. Энэ нь хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд том дэмжлэг болсон.

1.10. Түмэнцогт сумын цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах, хамтын ажиллагаагаа сайжруулах зорилгоор багш, туслах багш, ажилчдын хамтарсан баг, Түмэнцогт суманд 1 өдөр ажиллав.

**Соёл:** 2022 оны үйл ажиллагааны тайлан, гэрээний биелэлтийг дүгнүүлж аймгийн хэмжээнд 88,9 хувьтай үнэлүүлж 3-р байр эзэллээ.

Аймгийн соёл урлагийн газраас зохион байгуулсан тайлан дүгнэх хурал зөвлөгөөнд холбогдох албан хаагчдыг бүрэн хамрууллаа.

Байгууллагын 5 албан хаагчдыг ур чадварын уралдаанд амжилттай оролцуулж Хөгжмийн багш шилдэг багшаар шалгарлаа.

12 –р сард 7 нэгдсэн арга хэмжээнд 780 үйлчлүүлэгдийг хамрууллаа.

**НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Номын сангийн танхимын үйлчилгээгээр 120 иргэд, хүүхэд 360нэр төрлийн номоор, зөөврөөр 25 иргэнд 78 номоор нийт 145 иргэнд 438 номоор үйлчилсэн байна.Номын сангийн үйл ажиллагааны тайлан мэдээллийг холбогдох байгууллагад тайлагнаж ажилласан. Ном сэлгэн засварлалтын ажлыг хийж 300 гаруй номыг сэргээн засварлалаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500,000 төгрөгийн 31 нэр төрлийн ном худалдан авч фондны баяжилт хийлээ.

Номын сангийн явуулын үйлчилгээг 2 удаа зохион байгуулан 25 иргэнд 78 ширхэг номоор үйлчиллээ.

**СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Соёлын өвийг өвлөн уламжлагчдыг аймгийн телевизийн бичлэгэнд хамруулж ажилласан. Соёлын өвийг өвлөн уламжлагчдыг Тэргүүний ардын авьяастан цол тэмдэгт тодорхойлж 3 өвлөн уламжлагчийг Тэргүүний ардын авьяастан цол

тэмдгээр шагнуулсан.Бүртгэл мэдээллийн сангийн бааз үүсгэж 98 үзмэрийг бүртгэн баримтжуулаад байна.

**ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Бүжгийн дугуйлан 32 сурагчтайгаар нийт 7 удаагийн 11 цагийн сургалтыг зохион байгуулан ардын бүжгийн дасгалыг жигдрүүлэн ардын 4 бүжиг, цэнгээнт 2 бүжиг зааж улирлын тайлангаа хамгаалан ажиллаа. Хөгжмийн дугуйланд морин хуур 6, сурагчид 3 удаагийн 6 цагийн сургалтанд хамрагдлаа

**Эрүүл мэндийн чиглэлээр:** 2022 оны 12 сарын 22-ны байдлаар 21 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 14 насанд хүрэгчид, 7 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Амбулаторийн үзлэг 1175, урьдчилан сэргийлэх үзлэг 935байна.

Түргэн тусламжийн дуудлага 53 ирснээс алсын дуудлага–9, ойрын дуудлага44ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

0-17 насны 670 хүүхэд эрт илрүүлэг үзлэгт хамруулж 1838/1161 буюу 63.1% хамрагдаад байна.

“Хором бүрээ анхаарья” аяны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Архидан согтуурахаас сэргийлэх талаар иргэдэд мэдээллийг цахимаар болон ЭМТөвөөр үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгч зохион байгуулсан. “Архидан согтуурахаас сэргийлье” гарын авлага 60ш хэвлэн тараасан. Сумын хэмжээнд 15 дээш насны хүн амын дунд В,С вирусын шинжилгээнд хамрагдаагүй болон өөр орон нутагт хамрагдсан, вирустэй илэрсэн хүмүүсийн мэдээллийг программаас бүртгэж авах, тухайн иргэнтэй холбогдож мэдээлэл өгөх, нийт хүн амын дунд вирусын халдвар хэрхэн үүсэж буй талаар судалгаа хийх зорилготойгоор 5 багийн хүн амын мэдээллийг нэг бүрчлэн нягтлан

судалж шинжилгээнд хамруулах иргэд болон эмчилгээнд хамрагдах иргэдийн мэдээллийг шинэчиллээ. 2022 онд В,С вирус илэрсэн болон өмнө нь эмчилгээнд хамрагдаагүй иргэдэд мэдээлэл хүгэж гарын авлага тараасан.

ЭМТөвийн ажилчдад “Иргэдэд антибиотикийн зохистой хэрэглээг хэрхэн төлөвшүүлэх нь” сургалтыг зохион байгууллаа. Нийт 18 эмч ажилчид хамрагдлаа.

Ард иргэдэд “Антибиотик ямар хор нөлөөтэй вэ” гарын авлага 200 хэвлэн тараасан. ЭМТөвийн дотоодын сургалтанд сувилагч нарт “Үйлчлүүлэгчийн эмийн зохистой хэрэглээ” сургалтыг ээлжийн сувилагч нарт зохион байгуулж, хэвтэн эмчлүүлэгчидэд сургалтыг тогтмол хийж байна. Нийт 210 хэвтэн эмчлүүлэгчдэд зохион байгуулсан.

**Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:**

2022 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр нийт 491611 толгой мал тоологдож үүнээс тэмээ 502, адуу 44747, үхэр 37284, хонь 252062, ямаа 157216 болсон байна. Малтай өрх 1158, малчин өрх 966, малчдын тоо 1617 болоод байна.

12 сард адууны мах 71960 кг, үхрийн мах 162467, хонины мах 110922, ямааны мах 93415 кг махыг баталгаажуулж нийт гэрчилгээ 1117 бичиж, амьд мал адуу 398, үхэр 424, хонь 1837, ямаа 2792 бичгээр явсан байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.